

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/211/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН УНАГАЛДАЙН АНДУУД
ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК
Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/114
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД
СУМЫН УНАГАЛДАЙН АНДУУД
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ЦЭЦЭГЭЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9,819.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 10,502.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 26 арга

G/Архив/Албан бичиг 2023/ А4
19020196

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41,515,208.00</u>	<u>370,187,108.22</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	322,772,140.22
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	322,772,140.22
3121	Төгрөг	00.00	322,772,140.22
31211	Төрийн сангийн харилцах	00.00	322,772,140.22
35	БАРАА МАТЕРИАЛ	41,515,208.00	47,414,968.00
354	Хангамжийн материал	41,515,208.00	47,414,968.00
35460	Хүнсний материал	4,274,025.00	2,932,935.00
35470	Бусад хангамжийн материал	37,241,183.00	44,482,033.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,075,473,275.13</u>	<u>1,071,103,276.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,075,473,275.13	1,071,103,276.49
392	Биет хөрөнгө	948,457,858.22	943,693,276.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,034,595,394.00	1,036,595,394.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,232,184.16	-146,955,184.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,436,277.00	57,934,517.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,012,803.91	-21,519,093.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,601,097.51	43,222,727.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,929,922.22	-25,585,083.64
393	Биет бус хөрөнгө	127,015,416.91	127,410,000.00
39301	Программ хангамж	440,000.00	940,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-334,583.09	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	126,910,000.00	126,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,116,988,483.13</u>	<u>1,441,290,384.71</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,116,988,483.13</u>	<u>1,441,290,384.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,116,988,483.13	1,441,290,384.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,910,000.00	126,910,000.00
51101	Өмч: - төрийн	126,910,000.00	126,910,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	990,078,483.13	1,314,380,384.71
51210	Өмнөх үеийн үр дүн	990,078,483.13	-126,910,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,441,290,384.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,116,988,483.13</u>	<u>1,441,290,384.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	578,115,450.00	966,060,970.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,112,150.00	37,257,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	37,257,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	37,257,770.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	37,257,770.00
122	Тусламжийн орлого	3,112,150.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	3,112,150.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,849,700.00	928,803,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	806,671,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	806,671,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	455,153,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,144,900.00	4,212,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,144,900.00	4,212,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,704,800.00	117,919,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,704,800.00	117,919,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	602,344,891.69	644,848,968.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,344,891.69	644,848,968.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	487,241,157.06	629,908,567.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,625,098.00	364,789,191.70
210101	Үндсэн цалин	255,306,819.92	281,310,615.50
210102	Нэмэгдэл	66,318,278.08	67,822,493.18
210104	Урамшуулал	00.00	15,656,083.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,266,282.37	47,085,476.49
210201	Тэтгэврийн даатгал	37,413,501.37	34,306,912.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,277,890.00	3,414,993.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,022,313.00	2,622,794.56
210204	Ажилгүйдлийн даатгал	229,325.00	589,179.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,323,253.00	6,151,597.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,685,915.00	86,092,013.00
210301	Гэрэл, цахилгаан	2,056,905.00	5,008,208.00
210302	Түлш, халаалт	62,514,188.00	67,541,760.00
210303	Цэвэр, бохир ус	7,114,822.00	13,542,045.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,110,857.00	9,686,098.00
210401	Бичиг хэрэг	168,150.00	6,553,900.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	146,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	326,707.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,132,198.00
2105	Нормативт зардал	12,419,500.00	73,206,410.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,000.00	320,000.00
210502	Хоол, хүнс	11,221,650.00	64,268,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,179,850.00	8,618,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,620,440.00	748,030.00
210604	Урсгал засвар	2,620,440.00	748,030.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	175,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,433,064.69	48,126,348.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,476,720.00	12,114,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,240.00	1,716,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,481,104.69	34,296,268.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,103,734.63	14,940,400.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,844,900.00	13,284,915.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,873,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,971,800.00	3,550,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	9,734,115.58
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,797,264.63	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,797,264.63	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,461,570.00	1,655,485.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,398,885.00	1,655,485.01
213404	Хөрөнгийн	2,062,685.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-24,229,441.69	321,212,001.58
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	3,089,900.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	3,089,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	3,089,900.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-24,229,441.69	324,301,901.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	577,065,985.00	928,803,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,062,685.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,062,685.00	00.00
120009	Бусад орлого	2,062,685.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	575,003,300.00	928,803,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	806,671,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	806,671,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	455,153,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,144,900.00	4,212,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,144,900.00	4,212,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,704,800.00	117,919,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,704,800.00	117,919,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	574,666,587.00	596,211,459.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,666,587.00	596,211,459.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,562,852.37	581,271,059.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,675,606.26	365,715,834.96
210101	Үндсэн цалин	255,357,328.18	281,047,112.36
210102	Нэмэгдэл	66,318,278.08	69,012,639.58
210104	Урамшуулал	00.00	15,656,083.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,215,774.11	46,158,833.23
210201	Тэтгэврийн даатгал	30,484,141.89	32,724,657.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,083,826.41	3,581,049.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,443,541.03	2,769,139.37
210204	Ажилгүйдлийн даатгал	557,841.90	638,984.75
210205	Эрүүл мэндийн даатгал	5,646,422.88	6,445,001.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,685,915.00	85,540,700.00
210301	Гэрэл, цахилгаан	12,409,245.00	5,008,208.00
210302	Түлш, халаалт	56,162,240.00	66,210,916.00
210303	Цэвэр, бохир ус	3,114,430.00	14,321,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,508,950.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	144,750.00	103,500.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	201,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	33,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,660,200.00	00.00
2105	Нормативт зардал	16,114,364.00	62,927,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,707.00	00.00
210502	Хоол, хүнс	15,025,800.00	62,927,020.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,043,857.00	00.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,620,000.00	747,040.00
210604	Урсгал засвар	2,620,000.00	747,040.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	175,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	175,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,662,243.00	19,903,131.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,080,503.00	13,873,131.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	581,740.00	6,030,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,103,734.63	14,940,400.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,844,900.00	13,284,915.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,873,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,971,800.00	3,550,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	9,734,115.58
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,859,949.63	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,859,949.63	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,398,885.00	1,655,485.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,398,885.00	1,655,485.01
213404	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,399,398.00</u>	<u>332,591,740.22</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,399,398.00	9,819,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,399,398.00	9,819,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,399,398.00	9,819,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,399,398.00	9,819,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,399,398.00</u>	<u>-9,819,600.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	322,772,140.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	322,772,140.22

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,910,000.00	00.00	1,014,307,924.82	1,141,217,924.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,910,000.00	00.00	1,014,307,924.82	1,141,217,924.82
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,229,441.69	-24,229,441.69
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,910,000.00	00.00	990,078,483.13	1,116,988,483.13
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,910,000.00	00.00	990,078,483.13	1,116,988,483.13
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-1,116,988,483.13	-1,116,988,483.13
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,910,000.00	00.00	-126,910,000.00	00.00
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	324,301,901.58	324,301,901.58
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,910,000.00	00.00	197,391,901.58	324,301,901.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	924,590,900.00	600,163,274.77	324,427,625.23	64.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924,590,900.00	600,163,274.77	324,427,625.23	64.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,638,000.00	590,429,159.19	324,208,840.81	64.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	648,998,800.00	365,715,834.96	283,282,965.04	56.35
210101	Үндсэн цалин	516,793,700.00	281,047,112.36	235,746,587.64	54.38
210102	Нэмэгдэл	123,554,000.00	69,012,639.58	54,541,360.42	55.86
210104	Урамшуулал	8,651,100.00	15,656,083.02	(7,004,983.02)	180.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,124,900.00	46,158,833.23	34,966,066.77	56.90
210201	Тэтгэврийн даатгал	55,165,000.00	32,724,657.97	22,440,342.03	59.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,489,900.00	3,581,049.32	2,908,850.68	55.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,192,000.00	2,769,139.37	2,422,860.63	53.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,298,000.00	638,984.75	659,015.25	49.23
210205	Эрүүл мэндийн даатгал	12,980,000.00	6,445,001.82	6,534,998.18	49.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,540,700.00	85,540,700.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	10,520,000.00	5,008,208.00	5,511,792.00	47.61
210302	Түлш, халаалт	67,541,800.00	66,210,916.00	1,330,884.00	98.03
210303	Цэвэр, бохир ус	7,478,900.00	14,321,576.00	(6,842,676.00)	191.49
2105	Нормативт зардал	68,281,700.00	62,369,020.00	5,912,680.00	91.34
210502	Хоол, хүнс	68,281,700.00	62,369,020.00	5,912,680.00	91.34
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,750,000.00	2,747,040.00	2,960.00	99.89
210604	Урсгал засвар	2,750,000.00	2,747,040.00	2,960.00	99.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,406,000.00	1,602,800.00	(196,800.00)	114.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,000.00	1,602,800.00	(196,800.00)	114.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,535,900.00	26,294,931.00	240,969.00	99.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,505,900.00	20,264,931.00	240,969.00	98.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,030,000.00	6,030,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,952,900.00	9,734,115.58	218,784.42	97.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,952,900.00	9,734,115.58	218,784.42	97.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,952,900.00	9,734,115.58	218,784.42	97.80
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	924,590,900.00	924,590,900.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	806,671,900.00	806,671,900.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	806,671,900.00	806,671,900.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	117,919,000.00	117,919,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	117,919,000.00	117,919,000.00	-	100.00

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		322,772,140.22	(322,772,140.22)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,212,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,212,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	661,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00
210401	Бичиг хэрэг	103,500.00
2105	Нормативт зардал	558,000.00
210502	Хоол, хүнс	558,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,550,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,550,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,550,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,212,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,212,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,212,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Орон нутгийн болон бага насны хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэн, хүүхэд нэг бүрийг бүтээлээр хөгжих, төлөвших боломжийг бий болгох” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу тус байгууллагын 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 324,301.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	322,772.1	322,772.1
Авлага	-	-	-
Бараа материал	41,515.2	47,414.9	5,899.7
Үндсэн хөрөнгө	1,075,473.3	1,071,103.3	(4,370.0)
Нийт хөрөнгийн дүн	1,116,988.5	1,441,290.3	324,301.8
Өглөг	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	126,910.0	126,910.0	-
Хуримтлагдсан үр дүн	990,078.5	1,314,380.3	324,301.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,116,988.5	1,441,290.3	324,301.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 322,772.1 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,899.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,370.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9,819.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 10,502.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 806,671.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,919.0 мянган төгрөгийн, нийт 924,590.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 7 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхэр 924,590.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 806,617.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,919.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 806,617.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 117,919.0 төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 600,163.3 мянган төгрөгийг зарцуулж, 322,772.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 600,163.3 мянган төгрөг буюу 64,9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 283,282.9 мянган төгрөг, нормативд зардал 5,912.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 240.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	80111-Төрийн байгууллагын тогтмол зардал	88,290.7	88,290.7	-	100.0
1.2	80112-Нийтлэг үйлчилгээ	29,628.3	29,628.3	-	100.0
1.3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,900.0	1,900.0	-	100.0
1.4	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	68,281.7	69,738.8	(1,457.1)	102.1
1.5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,366.7	2,366.7	-	100.0
1.6	81823-Сурагчийн дүрэмт хувцас	1,800.0	1,560.0	240.0	86.7
1.7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	668,354.7	375,387.1	292,967.6	56.2
1.8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	63,968.8	58,516.6	5,452.2	91.5
Дүн		924,590.9	627,388.2	297,202.7	67.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 4,212.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, бараа үйлчилгээний зардалд 661.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 3,550.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Унагалдайн Андууд цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 806,671.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,100.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,075.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил 283,282.9 мянган төгрөг, нормативд зардал 5,912.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 240.9 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 167 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 484.5 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 28,381.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилт 100 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Зөвлөмж	3	28,381.0	3	28,381.0	100.0
Нийт дүн	3	28,381.0	3	28,381.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,842.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 6,842.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 6,842.7 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант онд цэвэр, бохир усны зардлыг 6,842.7 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд цэвэр, бохир усны зардлыг 6,842.7 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй	1	6,842.7	-	-	1	6,842.7	-	-	-	-	-	-
Дүн	1	6,842.7	-	-	1	6,842.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 167 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn